



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 10 сарын 14 өдөр

Дугаар A/360

Улаанбаатар хот

**Баянзүрх дүүрэг дэх Цагдаагийн газрын
Хоёрдугаар хэлтсийн балансаас
хөрөнгө шилжүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 5.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 92,968,600.00 /ерэн хоёр сая есөн зуун жаран найман мянга зургаан зуу/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг “Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар” ОНӨААТҮГ-ын балансад шилжүүлж данс бүртгэлээс хасахыг Баянзүрх дүүрэг дэх Цагдаагийн газрын Хоёрдугаар хэлтэс /Т.Оюунбаатар/-т зөвшөөрсүгэй.

2. Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, зарчмыг баримтлан бараа, материалын дансандаа бүртгэж авахыг “Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар” ОНӨААТҮГ /Г.Баттулга/-т үүрэг болгосугай.

3. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Баянзүрх дүүрэг дэх Цагдаагийн газрын Хоёрдугаар хэлтэс /Т.Оюунбаатар/, “Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар” ОНӨААТҮГ /Г.Баттулга/-т тус тус үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтэс /С.Ариунжаргал/-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ


Ш.ҮНЭНБАТ

111928240

ID: Tushaal 2019 \Tushaal

115050001091

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын
газрын даргын 2019 оны 10 сарын
14 өдрийн 01360 дугаар тушаалын хавсралт



Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянзүрх дүүргийн Цагдаагийн хоёрдугаар хэлтэс

№	Эд хөрөнгийн нэр	Марк, үзүүлэлт	Ашиглалтанд орсон	Хэм нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Шилжүүлэн авах байгууллага
Бусад үндсэн хөрөнгө										
1	Халаалтын тогоо	МХУТ-1.0 мВт	2016	ш	1	43,500,000.00	43,500,000.00	24,650,000.00	18,850,000.00	Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар ОНГААТҮГ
2	Халаалтын тогоо	МХУТ-0.7 мВт	2016	ш	1	40,561,429.00	40,561,429.00	22,984,809.88	17,576,619.12	
3	Өргөлтийн насос	TD65-3412 2900 об/мин	2016	ком	1	8,907,171.00	8,907,171.00	5,047,396.90	3,859,774.10	
Бусад үндсэн					3		92,968,600.00	52,682,206.78	40,286,393.22	
Нийт хөрөнгийн дүн							92,968,600.00			